



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР, ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ
БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД 1971-1975
ОНД ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР ХАМТ-
РАН АЖИЛЛАХ ТУХАЙ БАЙГУУЛСАН

Х Э Л Э Л Ц Э Э Р

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн Газар, монгол, зөвлөлтийн ард түмний хооронд тогтсон найрамдал, эх дүү ёсны харилцан туслалцах зарчмын үүднээс,

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг цэвэрд хөгжүүлэхийг эрмэлзэн,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газрын хүсэлтийг харгалзаж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улс ардын аж ахуйг 1971-1975 онд хөгжүүлэхэд эдийн засгийн тусламж үзүүлэх зорилгоор дор дурдсан зүйлсээр харилцан тохиролцов.

Нэгдүгээр зүйл

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн Газар нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улс ардын аж ахуйг 1971-1975 онд хөгжүүлэх арга хэмжээнүүдийг биелүүлэх, тухайлбал, хөдөө аж ахуй, ууны өмнө Бүгд Найрамдах Монгол Ард Улсын мал аж ахуйн материал-техникийн баазыг бэхжүүлэх болон түүний төвөөр чанарыг дээшлүүлэх, аж үйлдвэр, барилгын үйлдвэр, тээвэр, холбоог хөгжүүлэх, түүнчилэн геологи хайгуулын ажлыг явуулах, орон сууц, нийгэм ажуйн барилгуудыг барих, урьд байгуулсан Монгол-Зөвлөлтийн Хэлэлцээрүүдэд зөвсөн

барилга байгууламжийг барьж дуусгах, Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Зөвлөлт Холбоот Улстай хамтран барьж байгуулсан үйлдвэрийн газруудын үйлдвэрлэлийн хүчин чадлыг эзэмших, тэдгээрийг ажиллуулахад туслалцаа үзүүлэх талаар хамтран ажиллана.

Хоёрдугаар зүйл

Зөвлөлтийн барилгын байгууллагуудын хүч хөрөнгөөр болон ЗСБНХУ-ын техникийн туслалцаатайгаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсад барих буюу өөрчлөн байгуулах тодорхой барилга байгууламж, хийж гүйцэтгэх бусад ажил, түүнчилэн байгуулагдсан үйлдвэр байгууламжийн ашиглалтад үзүүлэх тусламж нь БНМАУ, ЗСБНХУ-ын жил бүрийн төлөвлөгөөний зохицуулалтын үндсэн дээр болон урьдчилан боловсруулсан техник-эдийн засгийн буюу бусад үндэслэлийн үр дүнг харгалзан, жил бүр гарын үсэг зурж энэхүү Хэлэлцээрт хавсралт болгон гаргах зохих протоколуудаар шийдвэрлэгдэж байх болно.

Дараагийн жилүүдэд барихаар төлөвлөж төлөвлөгөөт жилд төсөл- хайгуулын ажлыг нь хийх барилга байгууламжийн загсаалтыг Талууд жил бүр тохиролцож байна.

Техник эдийн засгийн болон бусад төрлийн үндэслэлийг монгол, зөвлөлтийн байгууллагууд энэхүү Хэлэлцээрийн I-р хавсралтын дагуу хийж гүйцэтгэнэ.

Гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд заасан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн Газар нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт / I рубль нь 0,987412 грамм цэвэр алттай тэнцэх / 570 сая рублийн хэмжээний зээлийг жилийн 2 хувийн хүүтэйгээр олгоно. Үүнээс:



200 сая хүртэлх рублийг хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд, нууны өмнө БНМАУ-ын мал аж ахуйн материал техникийн баазыг бэхжүүлэх, түүний тэвээрлэг чанарыг дээшлүүлэхэд олгоно.

100 сая хүртэлх рублийг аж үйлдвэр, барилгын үйлдвэрийг хөгжүүлэх, геологи хайгуулын ажил явуулахад олгоно. Дурдсан хөрөнгийг БНМАУ-д байгуулагдсан үйлдвэрлэлийн хүчин чадлыг аль болохоор бүрэн ашиглах, түүнчилэн өнгөт металл, хайлуур жонш олзворлох үйлдвэр, ойн болон мод боловсруулах үйлдвэр, түлш эрчим хүчний үйлдвэр, ард түмний өргөн хэрэгцээний бараа үйлдвэрлэх үйлдвэрийг байгуулах буюу өргөтгөхөд зориулна.

15 сая рублийг тээвэр, холбоог хөгжүүлэхэд олгоно. Зээлийн энэ хэсгийг нууны өмнө БНМАУ-ын материаллаг үйлдвэрлэлийн хэрэгцээг үйлчлэх тээвэр, холбооны ажлыг сайжруулахад чиглүүднэ.

5 сая рублийг БНМАУ-ын улс ардын аж ахуйг хөгжүүлэх тодорхой чиглэл болон 1971-1975 он, 1975 оноос хойших хугацаанд баригдах зарим барилга байгууламжийн техник-эдийн зэсгийн үндэслэл боловсруулахтай холбогдсон зардлыг төлөхөд олгоно.

50 сая рублийг орон сууц, нийгэм ахуйн барилга барихад олгоно. /Хөдөө аж ахуй, аж үйлдвэр хөгжүүлэхэд зориулан олгосон зээлийн хэсгээс санхүүжигдэн шинээр баригдах хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн барилга байгууламжийн бүрэлдэхүүнд орж баригдах орон сууцны барилгын хөрөнгөөс гадна/

200 сая рублийг БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын бараа гүйлгээний төлбөрийг тэнцүүлэхэд олгоно. Монголын Төл



энэхүү зээлийн үндсэн хэсгийг БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1971-1975 онд харилцан бэрээ нийлүүлэх тухай байгуулах Хэлэлцээрийн хэмжээнд багтаан, нууны урьд хөдөө аж ахуйд ажиллагсдын хэрэгцээт бэрээ түүнчилэн хөдөө аж ахуйн техникийг ЗСБНХУ-аас худалдан авахад чиглүүлнэ. Зээлийн энэ хэсгийг ирэх таван жилд жил бүр өшиглэх хугацаа нь БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1971-1975 онд харилцан бэрээ нийлүүлэх тухай байгуулах Хэлэлцээрээр тодорхойлогдоно.

Мөн түүнчилэн зөвлөлтийн барилгын ажилчдыг томилох, ажиллуулахтай холбогдсон зардлын зарим хэсгийг төлөхөд зориулан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт 25 сая рублийн хэмжээний буцалтгүй тусламж үзүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт урьд олгосон зээлийн үндсэн ер ба хүүгийн 1971-1975 онд төлөгдвөл зохих 540 орчим сая рублийн хэмжээний төлбөрийг Монголын Төл 1981 оны нэгдүгээр сарын I-нээс эхлэн 15 жилийн туршид жил бүр адил хэмжээтэйгээр төлнө. Тэхдээ төлбөр хойшлуулсан хугацаанд зээлд хүү ноогдуулахгүй, өөрөөр хэлбэл төлбөрийн хугацаа нь болсон өдрөөс эхлэн 1980 оны арван хоёрдугаар сарын 31 хүртэлх хугацаанд үндсэн өрийн тэрхүү хэсэгт хүү ноогдуулахгүй.

Төвдүгээр зүйл

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар энэхүү Хэлэлцээрийн дагуу олгосон зээлийг, 1976 оны нэгдүгээр сарын I-нээс эхлэн 15 жилийн туршид жил бүр адил хэмжээгээр,

Монгол-Зөвлөлтийн Худалдааны Хэлэлцээрийн нөхцөлүүдээр монголын барааг ЗСБНХУ-д нийлүүлэх замаар төлнө. Зээлийн ашигласан хэсэгт тэр өдрөөс эхлэн ноогдуулсан хүүг тэрхүү хүүг бодсон оны дараагийн жилийн I-р улиралд багтаан төлнө.

Энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлийн заалт нь энэ Хэлэлцээрийн гурөвдүгээр зүйлийн дагуу олгогдсон зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөрийн дүнд хамарагдахгүй.

Энэхүү Хэлэлцээрээр БНМАУ-д нийлүүлэх тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, механизм, материал болон бусад бэрээны төлбөрт олгосон зээлийн ашигласан өдрийг тэдгээрийг нийлүүлсэн өдрөөр, техникийн туслалцааны бусад зүйлийн төлбөрт олгосон зээлийн ашигласан өдрийг зөвлөлтийн байгууллагуудаас нэхэмжлэхийг бичсэн өдрөөр тооцно.

Зургадугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр ёсоор олгосон зээлийн ашиглалт, төлбөр, түүнд ноогдуулсан хүүг бүртгэх зорилгоор БНМАУ-ын Улсын Банк, ЗСБНХУ-ын Улсын Банк нь тус тусын нэр дээр зээлийн тусгай данснуудыг нээж, уг данснуудыг хөтлөх, зээлийн тооцоо хийх техникийн журмыг хамтран тогтооно.

Талуудын Банкууд түүнчилэн энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлд заасны дагуу төлбөр хойшлуулах техникийн журмыг тохиролцоно.

Долдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт заасан хамтын ажиллагааг биелүүлэх зорилгоор зөвлөлтийн байгууллагууд:

Аз үйлдвэр, хөдөө аж ахуйн болон бусад барилга байгууламжийг барих зураг төсөл-хэйгуулын ажлыг хийнэ;

Барилга байгууламжийг барихад зориулан БИМАУ-аас олж нийлүүлэх боломжгүй тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, механизм, материал сэлбэг хэрэгслийг нийлүүлнэ;

Барилга байгууламжуудыг байгуулахад техникийн туслалцаа үзүүлнэ. Түүнчилэн шаардлагатай үед Зөвлөлт Холбоот Улсын техникийн туслалцаатайгаар баригдсан үйлдвэрийн газруудын тоног төхөөрөмжинд шинэчлэлт хийж өгнө.

1964 оны гуравдугаар сарын 17-ны Монгол-Зөвлөлтийн Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлийн дагуу зөвлөлтийн барилгын ажилчдын Бүгд Найрамдах Монгол Ард Улсад томилогдон ажиллах байгаа хугацааг 1975 он дуустал сунгана. Зөвлөлтийн барилгын ажилчдын тоог гүйцэтгэх ажлын хэмжээнд тохируулан зөвлөлтийн байгууллагууд тогтоож байна.

Барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах, тохируулах, ашиглалтад оруулахад туслалцаа үзүүлэхээр зөвлөлтийн мэргэжилтнүүдийг 1971-1975 онд БИМАУ-д томилон ажиллуулна.

ЗСБНХУ-ын техникийн туслалцаатайгаар байгуулсан үйлдвэрийн газруудын үйлдвэрлэлийн хүчин чадлыг эзэмших, тэдгээрийг ажиллуулахад монголын байгууллагуудад мэргэжилтнийг томилон явуулах, тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх замаар туслалцаа үзүүлнэ.

Монголын мэргэжилтэн болон ажилчдыг үйлдвэрлэл - техникийн мэргэжилд сургахээр ЗСБНХУ-д хүлээн авна.

Наймдугаар зүйл

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газраас, энэхүү Хэлэлцээрт заасан хамтын ажиллагааг ханган биелүүлэхийн тулд:

Энэхүү Хэлэлцээрт дурдсан үүргээ гүйцэтгэхэд нь зөвлөлтийн байгууллагуудад бүх талын туслалцаа үзүүлэх,

тухайлбал барилга барих газрыг цаг тухайд зааж өгөх, бололцоотой газарт ус, илчээр хангах, түүнчилэн БНМАУ-аас олж нийлүүлж болох барилгын болон шатах, тослох бусад материалыг худалдан авахад туслахээс гадна энэ Хэлэлцээрийг биелүүлэх явцад гарч болох бусад бүх асуудлыг түргэн шийдвэрлэж байна.

Барилга байгууламжуудын зураг төслийг хийх, барилгын ажлыг гүйцэтгэх, тэдгээрийг хүн хүч, тээврийн хэрэгсэл, ус, илч болон БНМАУ-д олдох бололцоотой материалаар тус тус хангахын гадна бүх ажлыг санхүүжүүлнэ.

Энэхүү Хэлэлцээрийн дагуу БНМАУ-д барьж байгуулсан хийгээд шинэчлэн байгуулсан үйлдвэрийн газруудыг ажиллуулахад шаардагдах өөрийн боловсон хүчнийг /удирдах хүмүүс, мэргэжилтэй ажилчид/ зөвлөлтийн байгууллагуудын туслалцаатайгаар цаг тухайд нь бэлтгэх, зохих ёсоор бүрэн хангах үүргийг Монголын Тал хүлээнэ. Түүнчилэн тэдгээр үйлдвэрийн хэвийн ажиллагааны нөхцөл, түүхий эд, ашиглалтын материал болон сэлбэг хэрэгслийг хангана.

Есдүгээр зүйл

Үйлдвэрийн хүчин чадлыг эзэмших болон үйлдвэр аж ахуйн газрыг ашиглахад монголын байгууллагуудад туслалцаа үзүүлэхээр энэхүү Хэлэлцээрийн долдугаар зүйлийн дагуу томилогдон ажиллах зөвлөлтийн мэргэжилтэн, мэргэжлийн ажилчид нь монголын үндэсний боловсон хүчнийг ажил дээр дагалдуулан сургах ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэнэ.

Шаврдлагатай тохиолдолд Монголын Тал зарим үйлдвэр, аж ахуйн газрын техникийн болон захиргаа-техникийн

удирдлагын эрхийг зөвлөлтийн мэргэжилтэнд олгоно.

Арвдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн дагуу зөвлөлтийн мэргэжилтнүүдийг БНМАУ-д томилон явуулах, монголын мэргэжилтнүүд болон ажилчдыг үйлдвэрлэл-техникийн мэргэжилд сургахаар ЗСБНХУ-д хүлээн авахад мэргэжилтнийг харилцан томилон явуулах тухай Монгол-Зөвлөлтийн 1958 оны дөрөвдүгээр сарын II-ний өдрийн Хэлэлцээр, мөн түүнд гаргасан 1961 оны долдугаар сарын 22-ны өдрийн Протокол, монгол-зөвлөлтийн мэргэжилтэн, ажилчдыг үйлдвэрлэл-техникийн мэргэжилд сургах тухай 1958 оны дөрөвдүгээр сарын II-ний өдрийн Хэлэлцээрийн нөхцөлийг баримтлана.

Энэхүү Хэлэлцээрийн долдугаар зүйлийн дагуу зөвлөлтийн байгууллагуудын үүргээ биелүүлэхтэй холбогдсон зардлын төлбөрийг энэхүү Хэлэлцээрийн гуравдугаар зүйлд дурдсан 570 сая рублийн зээлээс Монголын Төл төлнө.

Монгол-Зөвлөлтийн 1964 оны гуравдугаар сарын 17-ны Хэлэлцээрийн дагуу томилогдон очсон зөвлөлтийн барилгын ажилчдыг БНМАУ-д байлгахтай холбогдсон монголын байгууллагуудын төлбөрийг мөн Хэлэлцээрийн нөхцөлийн дагуу тодорхойлон Монголын Төл дээрх зээлийн хөрөнгөнөөс төлнө.

Арван нэгдүгээр зүйл

Монгол-Зөвлөлтийн 1967 оны арван нэгдүгээр сарын 13-ны өдрийн Хэлэлцээр болон Монгол, Зөвлөлтийн Талуудын хооронд хожим байгуулсан Протоколууд, солилцсон бичгүүдээр шийдвэрлэгдсэн, энэхүү Хэлэлцээрийн 2-р хэвсрэлтэд дурдсан барилга байгууламжуудыг 1971-1975 онд барьж дуусгахыг Зөвлөлт Социалист Бүгд Нийрамдах Холбоот Улсын Засгийн газар зөвшөөрнө.

Эдгээр барилга байгууламжийг 1971-1975 онд барьж дуусгахтай холбогдон гарах зөвлөлтийн байгууллагуудын зардлыг,

Монгол-Зөвлөлтийн 1965 оны дөрөвдүгээр сарын 19-ний болон 1967 оны арван нэгдүгээр сарын 13-ны Хэлэлцээрүүдээр олгосон зээлийн амгилгагддаггүй хэсэгт багтаан, түүний нөхцөлөөр Монголын Төл төлнө.

Арван хоёрдугаар зүйл

Монгол,Зөвлөлтийн эрх бүхий байгууллагууд хоорондоо контрактууд байгуулж, түүнд зураг төсөл- хайгуул,барилгын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж,механизм,материал, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, мэргэжилтийг томилох техникийн бусад төрлийн туслалцаа үзүүлэх хэмжээ,хугацаа болон бусад тодорхой нөхцөл,түүнчилэн тэдгээр байгууллагуудаас энэ Хэлэлцээрийн дагуу хүлээх тодорхой үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

Арван гуравдугаар зүйл


Энэхүү Хэлэлцээр гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Үүнийг 1970 оны арван хоёрдугаар сарын „28” ны өдөр Москва хотноо монгол, орос хэл дээр тус бүр хоёр эх хувь үйлдэв. Хоёр эх хувь адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ
АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ЭРХ ОЛГОСНООР



ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД
НАЙРАМДАХ ХОЛВООТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ
ОЛГОСНООР





Монгол-Зөвлөлтийн 1970 оны 12-р сарын 28 өдрийн Хэлэлцээрийн
1-р Хавсралт

БНМАУ-ын эдийн засгийг хөгжүүлэх тодорхой чиглэлүүд болон БНМАУ-д 1971-1975 онд эхний ээлжинд барих барилга байгууламжийн үр ашигтай байдлыг тодорхойлохоор боловсруулах техник - эдийн засгийн болон бусад үндэслэлийн Урьдчилсан

Х А Г С А А Л Т

:				:Техник-эдийн засгийн
НЭЭ:	Барилга байгууламжийн			:болон бусад төрлийн үн-
:	н э р			:дэслэл боловсруулах
:				:хугацаа, гүйцэтгэгч
:				:Зөвлөлтийн :Монголын
:				:Төл гүй- :Төл гүй-
:				:цэтгэнэ :цэтгэнэ
I	2	3	4	

А.Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах барилга байгууламжууд

1.Зөвлөлтийн барилгын байгууллагын хүчээр барьж байгуулахаар төлөвлөн буй барилга байгууламжууд х/

- 1 . Махны чиглэлийн иж бүрэн гурван аж ахуй 1971 он -
- 2 . Эрээнцэв, Орхон, Өндөрхаан, Бейдрэгийн урлийн хонины 4 аж ахуй болон Түмэнцогтын урлийн үхрийн нэг аж ахуй 1971 он -
- 3 . Билчээр сайжруулах Шаамарын станц 1971 он -



- 4 . Намар мал бэлтгэх, нядлах салбар /хөргүүл бүхий нядалгааны газар/ 1971 он -
- 5 . Чойбалсан, Дэрхан хотын орчимд бог болон бод мал бордох аж ахуй 1971 он -
- 6 . Хуучин сангийн аж ахуйг түшиглүүлэн хүнсний ногоо, төмс тариалах, сүү болон мал аж ахуйн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх төрөлжсөн аж ахуй зохион байгуулах 1971 он -
- 7 . Гурван аймгийн усны аж ахуйн үйлдвэрлэлийн бааз 1972 он -
- 8 . Жилд 2 сая тонн нүүрс гаргах хүчин чадалтай Өвдөг-худагийн нүүрсний ил уурхай /ил уурхай, төмөр зам, тосгон, өндөр хүчдэлийн цахилгааны шугам/ 1971 он -
- 9 . Хайлуур жоншны үйлдвэр /Хар - Айраг зэрэг/ 1971 он -
10. Эрдэнэтийн овооны зэс молибдений орд газрыг түшиглэсэн уулын баяжуулах комбинат 1971 он -
- II. Егүзэрийн орд газрын вольфрам, молибдений үйлдвэр 1972 он -



2.

- | | | |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|---|
| 12. Омнөдэлгэр, Модот, Жанчивлангийн цагаан тугалганы үйлдвэр | 1971 он | - |
| 13. Улаанбаатар хотын ноос угаах фабриккийн өргөтгөл | 1971 он | - |
| 14. Арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр | 1972 он | - |
| 15. БНМАУ-ын төвийн бүсний 1971-1975 оны эрчим хүчний хангамжийн схем | 1971 он | - |
| 16. Ойн нөөцийг их бүрэн ашиглах схем | 1973 он
/үндсэн чиглэлийг 1971 онд өх/ | - |
| 17. Сүхбаатар хотын мод боловсруулах комбинатыг модон байшин болон бусад модон эдлэхүүн үйлдвэрлэхээр шинэчлэн өргөтгөх | 1971 он | - |
| 18. Галт уулын хүрмэн чулууны Булган, Архангайн ордыг түшиглэн ханын хөнгөн бетон хэсэг үйлдвэрлэх газар, ил уурхайн хамт | 1971 он | - |
| 19. Улаанбаатар хотын тоосгоны заводыг жилд 55 сая ширхэг тоосго гаргах хүчин чадалд хүртэл өргөтгөх | 1972 он | - |



20. Улаанбаатар хотын элд, хайрга, чулууны
ил уурхай

- 1971 он

21. Холбооны хэрэгсэл, радио холбоо,
зурагт радио болон радиожуулал-
тыг хөгжүүлэх ерөнхий схем

1971 он -

22. Улаанбаатар хотын ерөнхий төлөв-
лөгөөний техник-эдийн засгийн
үндэслэл

1971 он -

23. БНМАУ-д бод малын яс боловсруулж
цавууны царцмаг бэлтгэх үйлдвэр
зохион байгуулах

1971 он -

П. ЗСБНХУ-ын техникийн туслал-
цаатайгаар монголын байгуулла-
гын хүчээр барихаар төлөвлөн
буй барилга байгууламжууд.х)

1. Эрдэс тэжээлийн 4 аймгийн үйлдвэр,
ил уурхайн аж ахуйн хамт

- 1971 он

2. Улаанбаатар, Дархан, Чойбалсан-
гийн орчмын сангийн аж ахуй, хөдөө
аж ахуйн нэгдэлд сүүний 15 ферм

- 1971 он

3. Шувуу фабрикийн тоног төхөөрөмж-
ийн шинэтгэл, хэсэгчилсэн өргөт-
гөл /50-100 мянган өндөглөгчийн
хүчин чадалд хүртэл/

1971 он -



3.

- | | | |
|---------------------------------------------------------------------------------------------------------|---------|---------|
| 4. Трактор, хөдөө аж ахуйн техник-ийн засварын газар/ тус бүр IO-25 трактор засварлах/ | - | 1971 он |
| 5. Трактор, хөдөө аж ахуйн техник засварын 9 газрыг өргөтгөх /тус бүр 120 трактор засварлах/ | - | 1971 он |
| 6. Говийн аймгуудад малын тэжээл тарихад зориулсан жижиг усжуулах систем | - | 1971 он |
| 7. Баруун аймгуудад малын тэжээл тарихад зориулсан жижиг усжуулах систем | - | 1971 он |
| 8. Хөдөө аж ахуйн хортонтой тэмцэх алба зохион байгуулах | - | 1971 он |
| 9. Хуучин сангийн аж ахуйнууд дээр малын тэжээлийн ургамлын үр үйлдвэрлэх хоёр тасгийг зохион байгуулах | - | 1971 он |
| 10. БНМАУ-ын мал аж ахуйг хөгжүүлэх IO-15 жилийн иж бүрэн төлөвлөгөө | - | 1972 он |
| 11. Хөргүүл бүхий нүүдлийн нядалгааны газар | 1971 он | - |



- | | | |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|-----------------------|
| 12. Үрэлийн 16 фермийн үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх | - | 1971 он |
| 13. Хөрсний эвдрэлтэй гэмцэх арга хэмжээ | 1972 он | - |
| 14. Аюулаас хамгаалах өвсний улсын фонд байгуулахад зориулан өвс хадах механикчсан хадлангийн 50 бригадыг тулгуур 3 баазын хамт зохион байгуулах | - | 1971 он |
| 15. Сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдлүүдэд өвс хадах механикчсан хадлангийн 100 бригад зохион байгуулах | - | 1971 он |
| 16. Тосонцэнгэлийн мод боловсруулах комбинатаас модон эдэлхүүн гаргалтыг нэмэгдүүлэхээр үйлдвэрийн зарим цехүүдэд өргөтгөл, шинэтгэл хийж, нэг загварын модон байшин угсрах барилга угсралтын нүүдлийн цуваа зохион байгуулах | 1972 он | - |
| 17. Улаанбаатар хотын дулааны хангамжийн схем | - | Хоёр Тал тохиролцоно. |
| 18. Хөдөө орон нутгийн хэрэглэгчдийг холбох цахилгааны шугам | - | 1972 он |



19. Авто машины техникийн үзлэг үйлчилгээний станцууд 1972 он -
20. БНМАУ-ын үйлдвэрлэх хүчнийг 10-15 жилд хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй их бүрэн ерөнхий схем - 1973 он

Б. Бусад төрлийн үндэслэл олох барилга байгууламжууд.

1. Зөвлөлтийн барилгын байгууллагын хүчээр барьж байгуулахаар төлөвлөн буй барилга байгууламжууд.х)

1. Ондөр ашиг нимтэй малаар хангагдсан тус бүр 200 үнээтэй сүүний хоёр ферм 1971 он -
2. Мал аж ахуйн хүрээлэнгийн дэрэгдэх билчээр тэжээлийн эрдэм шинжилгээний лаборатор 1971 он -
3. Хөдөө аж ахуйн механикжуулагчид, усны аж ахуйд мэрэгжлийн боловсон хүчин бэлтгэх техник-мэрэгжлийн сургууль 1971 он -
4. Орон сууц, соёл ахуйн барилга байгууламжууд хийгээд хөдөө аж ахуйн нэгдлийн байнгын баазыг байгуулахыг оролцуулан мал аж ахуйг хөгжүүлэх аж ахуй-зохион байгуулалтын



төлөвлөгөөг хоёр аймгийн хэмжээгээр боловсруулан хэрэгжүүлэх

1972 он

5. Хөдөө аж ахуйн болон авто машин сэлбэг хэрэгслийн агуулах

1972 он

6. Хөдөө аж ахуйн барилга байгууламжийг барьж байгаа барилгын байгуулагыг техникээр хангах, мөн түүний үйлдвэрлэлийн бааз, орон сууц, худалдааны барилга байгууламж

1971 он

7. Геологийн удирдах газрын үйлдвэрлэл-лабораторийн төв бааз Улаанбаатар хотод

1971 он

8. Дархан хотын барилга үйлдвэрийн баазыг цахилгаан станцын дулааны шугаманд шилжүүлэх

1971 он

9. Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээ хос хоолойгоор тооцсон-оор 15 км урт

1971 он

10. Улаанбаатар баруун хэсэгт 500 номертой АТС кабель шугамын байгууламжийн хамт

1971 он

II. Чойбалсан хотын цэвэр усны гол шугам, усан сангийн байгууламж болон засмал зам/5 км хүртэл/

1971 он



II. ЭСБНХУ-н техникийн тусламжтайгаар монголын байгууллагын хүчээр барьж байгуулахаар төлөвлөн буй барилга байгууламжууд. х)

- 1. Үрийн агулаас хамгаалах улсын фонд хадгалах тус бүр 2000 тонн-н багтаамжтай 10 агуулах - 1971 он
- 2. Усны аж ахуйн үйлдвэрлэлийн бааз 10 аймагт - 1971 он
- 3. Хөдөө орон нутгийн хүн амд зориулсан нийт 65 мянган хавтгай дөрвөлжин метр сууцны талбайтай орон сууцныг соёл ахуйн барилга байгууламжийн хамт хөдөө аж ахуйн нэгдлүүдэд - 1971 он
- 4. Малчдыг үйлчлэхэд зориулсан нүүдлийн клуб, авто мухлаг, халуун усугаалга болон бусад тоноглогсон төхөөрөмж нийлүүлэх - 1971 он
- 5. 6400 уст цэг /усны хайгуул, төсөл хайгуулын ажлыг оролцуулан/ үүний дотор:
 - Яндант гүн худаг 1200
 - Богино яндант худаг 2200
 - Урхайн худаг 3000
 - 1971 он
- 6. Бог, бод малын 21 мянган хашаа барих - 1971 он



- | | | |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|---------|
| 7. Мал эмнэлгийн өргө хэмжээ /мал эмнэлгийн салбар, мал эмнэлгийн ариун цэврийн станц болон лабораторт мөн түүнчлэн малын арьсны хачиг хувалз гууртай тэмцэх отрядыг зохион байгуулахад зориулан их бүрэн тоног төхөөрөмж худалдан авах/ | 1971 он | - |
| 8. Долоон сангийн аж ахуйд үр цэвэрлэх салбарыг агуулахын хамт барьж байгуулах | - | 1971 он |
| 9. Ой, хээрийн түймэртэй тэмцэх отряд зохион байгуулах | 1971 он | - |
| 10. Хөрсний агро химийн лаборатор, | - | 1971 он |
| 11. Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, бригадын радио, телефон холбоо | - | 1971 он |
| 12. Дундговь аймгийн 500 номертой АТС /станцын үндсэн төхөөрөмж нийлүүлэх/ | - | 1971 он |
| 13. Улаанбаатарын зүүн хэсгийн АТС-ыг 2000 номероор өргөтгөх | - | 1971 он |
| 14. "Орбита" станцын хүлээн авах хэсгийг шинэчлэх | 1971 он | - |



6.

- | | | | |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|---------|---|
| 15. Холбооны шугамын нягтруулалт | - | 1972 он | |
| 16. Төмөр бетон гүүрүүд | - | 1971 он | |
| 17. Шагах, тослох материалын аж ахуйн тоног төхөөрөмжийг угсрах, засварлах албыг зохион байгуулах | - | 1971 он | |
| 18. Улсын нөөц агуулах тус бүр 2000 тонн-ын багтаамжтай хоёр нефть бааз | - | 1971 он | |
| 19. Улаанбаатар хотод 25 мянган хавтгай дөрвөлжин метр сууцны талбайтай орон сууц барихад хүрэлцээгүй материал, барилгын механизм, сантехникийн болон цахилгаан техникийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх | - | 1971 он | |
| 20. Улаанбаатар хотын ариутгах татуургын гол шугам болон цэвэрлэх байгууламж | 1971 он | | - |
| 21. Улаанбаатар хотын цахилгаан кабелийн болон агаарын шугам сүлжээ | 1971 он | | - |

х) Энэ жагсаалтанд дурьдсан хамтын ажиллагааны хэлбэр өөрчлөгдөж болно.



Монгол-Зөвлөлтийн 1970 оны 12-р сарын 28 өдрийн Хэлэлцээрийн 2-р Хавсралт

Монгол-Зөвлөлтийн 1967 оны 11-р сарын 13-ны лэнэлцээр болон удаа дараагийн Протоколууд, хоёр Талын захидлуудад дурдсан барилга байгууламжуудаас 1971-1975 онд барьж дуусгах барилга байгууламжийн

Х А Р С А А Л Т

Төрөл:	: үүрэг гүйцэтгэх
Д/д Барилга байгууламжийн нэр	: хугацаа
1 :	2 : 3

А. Зөвлөлтийн барилгын байгууламжын хүчээр

- | | | |
|---|-----------------------------------------------------------------------|--------------|
| 1 | Алтанбулагийн сангийн аж ахуйн 200 үнээтэй сүүний ферм | 1971 он |
| 2 | Мөрөн хотын гурилын тээрмийн дэргэдэх багсармал тэжээл үйлдвэрлэх цех | 1971 он |
| 3 | Улаанбаатар, Улиастайн мал эмнэлгийн бактер-шинжилгээний лаборатор | 1971-1972 он |
| 4 | Сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэлд барих засварын 3 газар | 1971-1972 он |
| 5 | Салхит, Тэсийн тэжээлийн станц | 1971 он |
| 6 | Баянхоигор, Сөйишандын усны аж ахуйн засварын 2 газар | 1971-1972 он |



- 7 Нийтдээ 15,75 мянган тонн багтаамжтай
үр тарианы механикжсан агуулах 1971 он
- 8 Механикжсан 10 үтрэм 1971 он
- 9 Нийтдээ 28 мянган тонн багтаамжтай
агуулаас хамгаалах тэжээлийн фонд
хадгалах 14 агуулах 1971 он
- 10 Хөдөө аж ахуйн мэргэжилтэй ажилчдыг
бэлтгэх 600 сурэгчидтай Баянчандманий
үйлдвэр-сургалтын төв /орон сууцны
байшин/ 1971 он
- 11 Зөвлөлтийн барилгын байгууллагын
үйлдвэрийн баз, тосгон, соёл ахуйн
болон худалдааны барилга байгууламжийн
хамт 1972 он
- 12 Чойбалсангийн хүнсний комбинат,
ээлжиндээ 10 тонн сүү боловсруулах
хүчин чадалтай цехийн хамт 1971 он
- 13 Ерөө-Бугантай-Толгойтын 110 кв
өндөр хүчдэлийн 75 км шугам, дэд
станцын хамт 1971 он
- 14 Дархан хотын дулааны цахилгаан
станцын хуваарилагч байгууламж хий-
гээд Дархан-Ерөөгийн 110 кв өндөр
хүчдэлийн шугам, дэд станцын хамт 1971 он
- 15 Улаанбаатарын дулааны 2-р цахилгаан
станцыг 12 мянган квт-аас 24 мянган
квт хүртэл өргөтгөж РОВ тавих
/ажиллаж байгаа хэсгийн засварын ажил/ 1971 он
- 16 Чойбалсан хот дахь 12 мянган квт хүчин
чадалтай дулааны цахилгаан станц,
дулаан болон цахилгааны гол шугамын
хамт /нүүрс дамжуулагч, цахилгааны
нэмэгдэл гол шугам болон бусад ажил/ 1971 он

- | | | |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|
| 17 | Дархан хотын 6000 тонн багтаамжтай нефть баз | 1971 он |
| 18 | Туул голын төмөр бетон гүүр, замын хамт | 1971 он |
| 19 | Улаанбаатар хотын "Зөйсөн", "Навдамин" гүүрийн хоорондох Туул голын үерийн хамгаалалтын далан | 1971 он |
| 20 | Улаанбаатарын зурагт радио станц /зурагт радионы кино үйлдвэр/ | 1972 он |
| 21 | Цогод сумын сургууль, эмнэлэг | 1971 он |
| 22 | Дархан хотын инженерийн гол шугам сүлжээний барилга /2-р ээлжийн нэмэгдэл ажил/ | 1971 он |
| 23 | Улаанбаатар хотын 5-р хороололд 17,5 мянган хавтгай дөрвөлжин метр талбайтай орон сууцны барилгын дуусгал | Талууд то-хиролцсоноор |
| 24 | Улаанбаатарт 16,4 мянган хавтгай дөрвөлжин метр талбайтай орон сууц | 1971 он |
| 25 | Улаанбаатар хотын 12,15-р хороолол хоорондох зам, мөн 12-р хороололын дундуур гарсан замаас Энх тайвны гудамж хүртлэх нэг талын хөдөлгөөнтэй зам | 1971 он |
| 26 | Чойбалсан хотод 3,6 мянган хавтгай дөрвөлжин метр талбайтай орон сууц | 1971 он |
| 27 | Чойбалсан хотод нийтдээ 4046 хавтгай дөрвөлжин метр талбайтай орон сууц | 1971 он |



28 Дархан хотод өдөрт 500 хүн х,лээн авч үйлчлэх нэгдсэн эмнэлэг болон 240 ортой эмнэлэгийн газар 1971 он

29 Эрдэнэтийн овооны зэс молибдений орд газрыг түшиглэн уулын баялуулах комбинат барьж байгуулах нь амигтай эсэхийг тогтсох техник-эдийн засгийн илтгэлд зориулсан инженерийн хайгуулын ажлыг оролцуулан, 1970 оноос хойш баригдах барилга байгууламжинд техник-эдийн засгийн үндэслэл зохиох шилжих ажлууд 1973 он

30 Ашиглалтанд орсон барилга байгууламжийн нэмэгдэл ажил болон тооцооны дуусгал/тухайн барилга байгууламжийг барихад хуваарласан зээлийн үлдэгдлээр тооцоно/ 1971 он

Б.ЭСБНХУ-ын техникийн туслалцаатайгаар Монголын байгууллагын хүчээр

1 Тус орны мал аж ахуйн тэжээлийн баазыг бэхжүүлэх иж бүрэн арга хэмжээ боловсруулах экспедиц 1972 он

2 Тус бүр 120 үнээтэй сүний 9 фермын барилгад тоног төхөөрөмж нийлүүлэх 1972 он

3 Төмрийн дархны газартай засварын 4 газар 1971 он

4 Мал эмнэлэгийн 34 салбар, мал эмнэлгийн ариун цэврийн 3 станц 1971 он

5 Усны аж ахуйн засварын 2 газар 1971 он

6 Аюулаас хамгаалах улсын тэжээлийн фонд хадгалах 16 агуулах 1972 он



- 7 Сангийн аж ахуйн бэлтгэл тэмдэгийн 7 цех 1973 он
- 8 Механик сан 4 үтрэм 1972 он
- 9 Хадлан нэмэг бэлтгэх болон агуулаас халгаслах тэмдэгийн фонд тээвэрлэхэд зориулан хөдөө аж ахуйн машин, трактор, тээврийн хэрэгсэл нэмэх нийлүүлэх 1972 он
- 10 Хөдөө аж ахуйн нэгдэл болон нэгдэл дундын барилгын байгууллагын хүчээр барих малын 12000 хашаа /тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, барилгын зарим материал нийлүүлэх/ 1971 он
- 11 Улсын барилгын байгууллагын хүчээр барих малын 4500 хашаа 1971 он
- 12 Зөвлөлтийн техник мэргэжлийн сургуульд монголын 200 иргэнийг хүлээн авч хөдөө аж ахуй, барилгын мэргэжилд сургах 1971 он
- 13 Улаанбаатар хотын ноосон нэхмэлийн фабрикын тоног төхөөрөмжийг одоо байгаа талбайд нь шинэчлэх 1971 он
- 14 Геологи хайгуулын аялууд 1971 он
- 15 Цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамд хөдөө орон нутгийн хэрэг-лэгчдийг холбоход зориулан тоног төхөөрөмж нийлүүлэх 1971 он
- 16 РСО маягийн 100 радио станц /нийлүүлж дуусгах/ 1972 он
- 17 Улаанбаатар хотын газар доорхи шугам сүлжээ 1971 он

C. A.

M. S.



18 Монгол-Зөвлөлтийн 1967 оны 11-р сарын 15-ны Хэмэлцээр болон удаа дараагийн протоколууд хийгээд хоёр Төлийн захирлын дагуу БНМАУ-д иймэлүүлсэн тоног төхөөрөмжийг зарим барилга байгууламдад угсарахад түүнчилэн үйлдвэрийн амьтгалт дээр Монголын байгууллагад техникийн тусламцаа үзүүлэхээр мэргэжилтнүүдийг томилох /тухайн барилга байгууламжийн хувинарт эзэлийн үлдэгдлээр гүйцэтгэнэ/